

1980-2000-ААД ОНЫ ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН
НИЙТЛЭЛИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, АГУУЛГА ХАНДЛАГЫН ТУХАЙД

Л.Ариун*

* ХИС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.)

Түлхүүр үг: экологийн сэтгүүл зүй, экологийн нийтлэл, бичлэгийн төрөл, зүйл, сэдэв, булан, агуулга.

Сонин хэвлэл уншигчдад байгаль орчны талаар мэдээлэл өгч хүрээлэн буй орчинтойгоо зөв зохистой харьцах, ашиглах, хамгаалах талаар мэдлэг олгох, төлөвшүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Энэ утгаараа экологийн нийтлэлийн бичлэгийн төрөл, цуглуулсан баримт, агуулга санаагаа уншигчдад хүргэх аргачлал зэрэг нь чухал ач холбогдолтой.

Монголын сонин хэвлэлийн бичлэгийн төрөл зүйлд 1990-ээд оноос хойш өөрчлөлт гарч өмнө нь том хэмжээтэй өгүүлэл, тэмдэглэл, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, найруулал голлож байсан бол 1990-ээд оноос хойш мэдээллийн бичлэгийн төрөл зүйл давамгайлах болжээ. Өнөөдөр манай сонин хэвлэлд мэдээ, сурвалжлага, ярилцлага зэрэг мэдээл-

лийн төрөл зүйл зонхилж байгааг судлаачид гаргасан нь бий. Энэ хандлага тогтмол хэвлэл дэх экологийн нийтлэлд ч ажиглагдаж байлаа.

Байгаль орчны нийтлэл өөрийн гэсэн онцлогтой юм. Бусад сэдэвтэй харьцуулахад статистик тоо баримт, мэргэжлийн нэр томъёо, судалгааны материалууд, хүний яриа, ишлэл зэргийг баримт болгон түшиглэн бичдэг. Энэ бүхнийг жирийн уншигчдад ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр хүргэх нь сэтгүүлчээс ур чадвар шаардсан ажил болдог билээ.


Мэдээллийн төрөл сэтгүүлчийн үйл ажиллагаа баримтыг дурдах төдийгөөр хязгаарлагддаг бол экологийн нийтлэлд тайлбар зонхилдог онцлогтой. Тиймээс экологийн нийтлэлийг мэдээллийн төрөл зүйлээр бичихэд үр өгөөж муутай, харин задлан шинжилсэн, нийтлэл-уран сайхны төрлөөр бичсэн экологийн нийтлэл үр нөлөө, үр дүнгээрээ хавьгүй илүү байдаг.

1980-аад оны "Үнэн" сонины экологийн нийтлэлийг бичлэгийн төрөл зүйлээр задлан үзвэл асуудал дэвшүүлсэн өгүүлэл, сурвалжлага, танин мэдүүлэх өгүүлэл давамгайлж, мэдээ, ярилцлага зэрэг мэдээллийн төрөл зүйл маш бага байгаа нь экологийн сэтгүүл зүйн мөн чанартай нийцэж байгаа юм. Тэрчлэн шинжлэлт өгүүлэл, нийтлэл уран сайхны төрлөөр ч бичиж байв.

Мэдээ 80-аад оны сүүл рүү ихсэх хандлагатай болсон. Харин уншигчдын захидал эсрэгээрээ 1980-аад оны эхэнд их гарч байснаа 1980-аад оны сүүл рүү

багасах хандлагатай болсон. Иргэдийн захидал 1987 оноос хойш багассаар 1990, 2000-аад маш бага хувьтай гарсан нь өдгөө нийгмийн тулгамдсан асуудлуудыг зүй ёсоор тэргүүлж байгаа байгаль орчны элэгдэл эвдрэл, тэнцвэрт байдлын алдагдлын талаар өнөөдрийн уншигч, олон нийт энэ асуудлыг төдийлөн анхаардаггүй нь харагдаж байгаа юм.

1980-аад оны өдөр тутмын томоохон хэвлэл "Үнэн" сонины экологийн сэдэвт нийтлэлийн төрөл зүйлд хийсэн судалгааг графикаар харуулбал:



1990-ээд оны экологийн нийтлэлийн ихэнх хувийг мэдээллийн бичлэгийн төрөлд хамаарах мэдээ, ярилцлага, сурвалжлагын хэлбэрээр бичжээ. Асуудал

дэвшүүлсэн нийтлэл 10-20 хувь, танин мэдүүлэх, шинжлэлт нийтлэл, иргэдийн захидал зэрэг нь маш бага хувь (6 хувь) нь 1990-ээд оны тогтмол хэвлэл дэх


экологийн нийтлэл хүүрнэ мэдээлэл тэдний өдөр нийтэд тухайн асуудлыг хүртээ үг нөлөөний хувьд сурвалжар байсан гэж дүгнэх болохоор байгаа юм. Учир нь 1990-ээд оны Ардын эрх Зүүнч мэдээ сонинуудын экологийн нийтлэлийн 30-60 гаруй хувийг гурав дөрөвхөн өгүүлбэр бүхий мэдээ эзэлж байна.

Байгаль орчныг сүйтгэж, хууль бусаар ан агнаж, алт олборлож байгаа

тухай сурвалжлага 25 орчим хувь, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага 15 хувь экологийн сэдвээр бичдэг цөөн сэтгүүлчийн асуудал дэвшүүлсэн өгүүлэл 10 орчим хувийг тус тус эзэлж байна.


1990-ээд оны өдөр тутмын томоохон хэвлэл "Ардын эрх", Засгийн газрын мэдээ" сонинуудад гарсан экологийн нийтлэлийн төрөл зүйлд хийсэн судалгааг графикаар харуулбал:

1990-ээд оны тогтмол хэвлэлийн экологийн нийтлэлийн төрөл зүйлийн хувь



2000-аад оны экологийн нийтлэлийн төрөл зүйлийн хувьд мөн л мэдээллийн бичлэгийн төрөлд багтах мэдээ, сурвалжлага ярилцлага тэргүүлжээ. Экологийн сэдвээр бичихэд хамгийн тохиромжтой асуудал дэвшүүлсэн өгүүлэл, шинжлэлт өгүүлэл, танин мэдүүлэх өгүүлэл маш бага хувьтай байгаа нь өнөөдрийн экологийн нийтлэлд оршиж буй нэг томоохон дутагдал юм. Өөрөөр хэлбэл экологийн нийтлэлийн 70 гаруй хувийг мэдээллийн бичлэгийн төрөл зүйл эзэлж байгаа нь өнөөдөр манай экологийн нийтлэл идэвхгүй, уншигчдад байгаль орчны сэдвийг зөвхөн баримт тоочсон, энд тэнд болсон үйл явдлыг мэдээлсэн маягаар өгч байгаа нь үр нөлөө тааруу юм.

2000-аад оны тогтмол хэвлэлийн экологийн нийтлэлийн төрөл зүйлийн хувь



2000-аад онд уран сайхны нийтлэл 10 орчим хувьтай байгаа бөгөөд үүнээс "Өдрийн сонин"-ы "Эх орон сумаас эхэлнэ" буланд гарсан нийтлэлүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Экологийн нийтлэл эх орны байгаль орчин сүйрч, бидний амьдарч буй хот суурингийн ус, агаарын бохирдол зэрэг байгаль экологийн бүхий л тулгамдсан асуудлыг дэлгэн тавьж, эрдэмтэд болон төр засаг цаашлаад олон нийтийн анхаарлыг хандуулж, байгаль орчноо хайрлан хамгаалах, нөхөн сэргээх ажилд идэвхтэй оролцуулах зорилготой байдаг. Иймээс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг сайжруулах, байгаль орчноо хамгаалах, хайрлах ажил үйлст уриалах нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын нэн тэргүүний үүрэг болоод байгаа юм.

1980-аад онд төр засаг, яам тамгын газрын удирдлага зэргийг нэр заан хүчтэй шүүмжилсэн нийтлэлүүд их гарч байжээ. 1990-ээд он, 2000-аад онд даацтай нухацтай нийтлэл цөөрч, байгаль экологийн холбогдолтой аливаа асуудлыг мэдээлэхээс хэтрэхгүй болсон дүр зураг ажиглагдаж байна.

Бичлэгийн төрөл зүйлд ямар өөрчлөлт гарч байсныг он тус бүрээр нь харьцуулбал дараах дүр зураг бууж байна:

Төрөл зүйл	1980-аад он	1990-ээд он	2000-аад он
Мэдээ	6.4 %	33.8 %	41.0 %
Сурвалжлага	22.0%	13.2 %	15.9 %
Ярилцлага	-	9.2 %	12.6 %
Асуудал дэвшүүлсэн өгүүлэл	38.2 %	10.5 %	8.0 %
Сурвалжилсан тэмдэглэл	8%	2.0%	5.0%
Уран сайхны нийтлэл	2.8 %	7.4 %	7.5 %
Танин мэдүүлэх өгүүлэл	11 %	19.6 %	6.4 %
Төр засгийн мэдээлэл	-	1.2 %	1.6 %
Иргэдийн захидал	5.6 %	1.2 %	1.0 %
Шинжлэлт өгүүлэл	5.2 %	0.9 %	0.6 %
Тэмдэглэл	0.8 %	1.0 %	0.4 %
Нийт	100%	100%	100%

Дээрх хүснэгтээс 1980-аад оноос хойш мэдээллийн бичлэгийн төрөл зүйлийн эзлэх хэмжээ эрс өсч, харин асуудал дэвшүүлсэн, шинжлэлт, танин мэдүүлсэн өгүүлэл, иргэдийн захидал буурч, мэдээ, сурвалжлага, ярилцлага голлох болсон нь харагдаж байна.

Манай тогтмол хэвлэлүүдийн экологийн сэдэвт нийтлэлийн үр нөлөө тааруухан байгаагийн нэг шалтгаан нь асуудлыг мэдээлэх төдийхнөөр өнгөрч буйтай холбоотой. Өөрөөр хэлбэл өнөөдөр экологийн сэдэвт нийтлэлийг асуудал дэвшүүлсэн, шинжилсэн, танин мэдүүлсэн зэрэг даацтай төрөл зүйлээр бичих нь монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэлийн өмнө тавигдаж байгаа нэг томоохон шаардлага билээ.

Экологийн тогтсон нүүр булангийн тухайд, 1980-аад оны "Үнэн" сонины

экологийн нийтлэлийн 80 орчим хувь нь байгаль экологийн тогтсон нүүр буланд гарч байжээ. "Хүн байгаль", "Дархан газар", "Бүх нийтийн чанарын үзлэг", "Байгаль хамгаалах сард", "Байгаль эхээ хайрлан хамгаалъя", "Хүн байгаль хууль", "Мөнгөлөг гацуур цомын төлөө", "Байгаль орчин", "Байгаль хамгаалах сарын ажил эхэллээ", "Эх орны ногоон хүрэм" нэртэй тогтмол нүүр, булангуудад байгаль орчны сэдэвтэй материалуудыг нийтэлдэг байсан нь энэ сэдвийг сонирхон уншдаг өөрийн гэсэн уншигчидтай болох, энэ сэдвийг тогтмол тусгадаг болох ач холбогдолтой юм.

Харин 1990, 2000-аад онд энэ үзүүлэлт эсрэгээр гарч 1990-ээд онд 80-аад хувь, 2000-аад онд 80 гаруй хувь нь тогтсон булан, нүүрт биш энд тэнд хэсэг бусад газар нийтлэгдэж байжээ. Энэ үеэс

байгаль орчны сэдвийг манай сонин хэвлэл тусгах асуудал урсгал маягаар явагдсан гэж үзэж болохоор байгаа юм. 1990-ээд оны "Ардын эрх", "Зууны мэдээ" сонинд экологийн нийтлэл "Хоёр нарны хооронд", "Баримт үйл явдал", "Сав шимийн ертөнц", "Байгаль, ан амьтан", "Миний төрсөн нутаг", "Байгалийн урлан", "Байгаль хамгаалал", "Монголын сайхан орон", "Хүн байгаль", "Байгалийн нууц" зэрэг цөөн буланд алдаг, оног гарч байжээ.

2000-аад оны тогтмол хэвлэл дэх байгаль экологийн сэдэвтэй нийтлэлүүд мөн л мэдээ, мэдээллийн 1-р нүүр, "Баримт үзэл, бодол" зэрэг нүүрэнд голдуу гарч байв. Хааяа нэг "Байгаль экологи" булан "Өдрийн сонин"-д ажилладаг байжээ. Харин 1990-ээд оны "Ардын эрх" сонинд "Эх орон - миний гэр" нэртэйгээр гарч байсан булан 2000-аад оны "Өдрийн сонин"-д "Эх орон сумаас эхэлнэ" нэртэй болж тогтмол ажиллаж байсныг хэлэх хэрэгтэй.

Энэ буланд сэтгүүлч, зохиолчид төрж өссөн нутаг усныхаа домог, түүх, байгалийн тогтоц, өвөрмөц онцлогийн тухай өгүүлсэн тэмдэглэл, нийтлэл уран сайхны нийтлэлийг бичдэг. Тухайлбал: Г.Жамцын "Хоргодуулах шидтэй Хорго минь" ("Ардын эрх". 1995, №86), О.Дашбалбарын "Наранбулаг - Миний бага эх орон" ("Ардын эрх". 1995, №135), Ц.Ванчиндоржийн "Гучин гурван говьдоо алдартай нутаг минь" ("Ардын эрх".

1995, №136), Ш.Пүрэвсүрэнгийн "Туруун нутаг минь" ("Өдрийн сонин". 2003, №123), Ц.Банзрагчийн "Хоёр голын сав Хонгорын сайхан нутаг минь" ("Өдрийн сонин". 2005, №135), Ш.Лхамноржмаагийн "Зүрхэнд үерлэх Чулуут" ("Өдрийн сонин". 2005, №261) зэргийг нэрлэж болно.

Байгаль экологийн булан нүүр тогтмол ажиллана гэдэг бол тухайн сонин байгаль орчны сэдвийг нийтлэлийнхээ бодлогод тусгаж байна гэсэн үг аж.

Судалгаа хийсэн сонинуудын экологийн нийтлэлийг агуулгынх нь хандлагаар үзлээ. Сөрөг хандлагатай нийтлэлд ган, зуд, үер, аадар бороо, газар хөдлөлт, хэт дулааралт, ой мод, зэрлэг ан амьтны ховордолт, халдварт өвчин, цөлжилт, ой хээрийн түймэр гэх мэт агуулгатайг, харин эерэг хандлагатайд мод бут тарих, тариа ногоо суулгах, зэрэг ан амьтны өсөлт, хот, ойр орчны хог хаягдлыг шийдвэрлэх, гол ус цэвэрлэлт, байгалийн баялаг, нөөц бололцоог үр ашигтай, зүй зохистойгоор ашиглалт, байгалийн эсрэг зүй бус үйлдэлтэй тэмцэж буй хувь хүн, албан байгууллага төр засгийн тэмцэл, агаарын бохирдлыг бууруулах шахмал түлш, ногоон хэрэм зэрэг агуулгатайг оруулж үзсэн болно. Мөн эерэг болон сөрөг агуулгыг аль алиныг нь агуулаагүй төвийг сахисан нийтлэлүүд гэсэн үзүүлэлтүүдээр авч үзлээ.

1980-аад оны "Үнэн" сонинд гарсан экологийн нийтлэлийн 57-2 хувийг сөрөг хандлагатай нийтлэл эзэлж 28 хувийг нь эерэг, үлдсэн 14.8 хувийг төвийг сахисан нийтлэл эзэлж байна. Сөрөг хандлага бүхий нийтлэлүүдээс дурдвал: Д.Навзачсүрэнгийн "Бохир тойргийн тухай дэхин ярихад" ("Үнэн". 1987, №39) нийтлэлд хог хаягдал, орчны бохирдол, хотжилт, түүнийг дагасан орчны бохирдолтын тухай асуудал дэвшүүлжээ. "Богд уул" ("Үнэн". 1987, №43) нийтлэлд Богд уулын түүх, байгалийн баялгийн тухай дэлгэрэнгүй мэдээлж, Богдхан ууланд хэн дуртай нь очиж самар түүж бохирдуулж байгааг шүүмжилсэн байна. Монгол орны ойн модны хомсдол, ойн нөөц, мод боловсруулах үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлуудыг дэлгэн тавьсан Г.Жамцын "Эх орны ногоон хүрэм сэглэгдэж байна" ("Үнэн". 1987, №47, 55, 61, 64, 68, 85, 99) цуврал нийтлэл 1987 оны "Үнэн" сонинд гарчээ. Д.Хүүхэнгаа. "Одоо л бодохгүй бол оройтно" ("Үнэн". 1987, №84) өгүүлэлд байгаль дэлхийтэй буруу харьцсанаас ус гол ширгэж байгааг баримтаар өгүүлжээ. Д.Цэнджавын "Заг сүйдлээ, хариу..." ("Үнэн". 1988, №114) нийтлэл говийнхон заг их хэмжээгээр хэрэглэж байна, энэ талаар сонин хэвлэл нийтэлсээр байтал арга хэмжээ авахгүй бахь байдгаараа байна, үүнийг хэзээ зогсоох вэ хэмээн асуудал дэвшүүлжээ. Г.Бадарчийн "Мод дуусах вий" ("Үнэн". 1988, №116) нийтлэлд Архангай

аймагт модны үйлдвэр, мод бэлтгэх зовшооролгүй үзэсгэлэнт ойг сүйтгэж хадлангийн талбайг хөрсөөр нь эргүүлж олон салаа зам гарган байгааг Байгаль орчны яамнаас анхааралдаа авахыг шаарджээ. 1980-аад оны экологийн сөрөг хандлага бүхий нийтлэлүүдийн сэдэв нь голдуу байгалийн баялгийг хайр гамгүй ашиглаж сүйдэлж байгааг сэрэмжлүүлж анхааруулсан байдаг.

Энэ үеийн эерэг хандлага бүхий нийтлэлүүдээс дурьдвал: М. Мэндбилэгийн "Усны нөөцийг ингэж ашигладаг" ("Үнэн". 1987, №82) нийтлэлд Киргиз улсад усыг хэрхэн ашиглаж байгааг өгүүлсэн бол, Д.Сэ-нэднасаагийн "Эзний сэтгэлээр хамгаалж байна" ("Үнэн". 1987, №105) сурвалжлагад төв аймгийн ойн агнуурын аж ахуй, ой хамгаалагч Х.Жүгдэрнамжил ажлаа сайн хийж буй тухай, Ш.Цэрэнпилийн "Дэлхийд алдартай уул" ("Үнэн". 1989, №221) Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байдаг Эргэлийн 300 хэмээх дэлхийд нэртэй ууланд олон зүйл ан амьтан байдаг төдийгүй эртний амьтдын олдвороороо дэлхийд алдартай тухай мэдээлжээ. Төвийг сахисан нийтлэлүүдийг нэрлэвэл: Я.Адъяагийн "Тарвага – үнэт баялаг" ("Үнэн". 1988, №202) өгүүлэлд Монгол орны тарваганы нутагшил, тоо толгой жилийн агналтын тоо, тарваганаас халдах аюулт өвчин, арьсыг нь өвчих технологи зэргийг мэдээлжээ.

Харин 1990-ээд оны "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинуудад гарсан байгаль орчны нийтлэлийн дийлэнх буюу 45 хувийг сөрөг, 35 хувийг эерэг, 20 хувийг төвийг сахисан хандлагатай нийтлэл эзэлж байгаа үзүүлэлт гарчээ.

Сөрөг нийтлэлүүдээс үзвэл: П.Ганбатын "Бугын эвэрчид аюул тарьж байна" ("Ардын эрх". 1995, №113) өгүүлэлд Сэлэнгэ аймагт энэ хавар их хэмжээний хохирол учруулсан нийт 13 түймэр гарсны гол буруутан нь бугын эвэр түүгчид болох тухай, Ш.Төмөрбаатарын "Байгаль - эсхүл алт..." ("Засгийн газрын мэдээ". 1995, №82) өгүүлэлд алт мөнгө байгаль ээжээс илүү болсон нь Монголын эмгэнэл юм гээд алтны үйлдвэрүүдэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар, Мөн Ц.Амарын "Ногоон бүсэд мод огтолж, зээр агнаачид илрэв" ("Засгийн газрын мэдээ". 1998, №238) өгүүлэлд ногоон бүсэд мод огтолж, зээр буудаж байсныг шалгалтаар илрүүлсэн тухай мэдээлжээ.

Эерэг хандлагатай нийтлэлийн жишээнд Г.Отгон. "Оюутнууд Туулын шугуйг цэвэрлэнэ" ("Засгийн газрын мэдээ". 1998, №249) сурвалжлага, Б.Жаргалын "Хангалын голын бохирдол багасчээ" ("Ардын эрх". 1995, №116) сурвалжилгад хариуцсан яамдууд хамтарч Эрдэнэт үйлдвэрээс байгаль орчны бохирдлыг бууруулах, арилгах чиглэлээр хийсэн ажлыг шалгасан шалгалтаар ийм дүнг

гарсныг мэдээлсэн бол, "Арваад газрыг тусгай хамгаалалтанд авав" ("Ардын эрх". 1992, №29) Засгийн газрын мэдэгдэлд Дархан цаазат газар, байгалийн цогцолбор газар гэдэгт ямар газар нутгийг хамааруулдаг хийгээд шинээр 10-аад газрыг хамгаалалтанд авсан тухай мэдээлсэн зэргийг оруулж үзлээ.

Төвийг сахисан хандлагатай нийтлэлүүдийн хувьд: "Бугын ясан эврийг түүж бэлтгэхэд баримтлах нийтлэг журам" ("Ардын эрх". 1992, №37) өгүүлэл Булган аймгийн Ардын хурлын гүйцэтгэх захиргаа аймгийнхаа нутаг дэвсгэрээс бугын ясан эвэр түүж бэлтгэхэд баримтлах журам баталсан тухай, Г.Жамцын "Хоргодуулах шидтэй хорго минь", Х.Өлзийбаярын "Сэнжирч гогцоорч харагдана", С.Товуудоржын "Үзэсгэлэнт түшээ гүн уул", "Дүнгэнэдэг Дүнгээ уул" ("Ардын эрх". 1995, №86) өгүүллүүд тухайн нутаг усны түүх, домог байгалийн тогтоцийн тухай өгүүлсэн бол "Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам" ("Засгийн газрын мэдээ". 1998, №176) Засгийн газрын журмын тухай, Ч.Бат. "Хөвчийн анг мөрөөр нь тоолно" ("Засгийн газрын мэдээ". 1998, №222) Булган аймагт ан амьтныг мөрөөр нь тоолох гэж байгаа тухай мэдээлжээ.

2000-аад оны "Өдрийн сонин", "Зууны мэдээ" сонинуудын байгаль орчны нийтлэлийн 63.5 хувийг сөрөг хандлагатай, 25 хувийг эерэг хандлагатай, үлдсэн 11.5 хувийг төвийг сахисан нийтлэлүүд

эзэлжээ. Сөрөг хандлагатай нийтлэлүүдийн жишээг үзье: Г.Эрхэсын "Найман шонхортой цүнх илэрчээ" ("Өдрийн сонин", 2001, №28) мэдээнд Берлинд Монголоос очсон хаяггүй ачаанаас найман шонхор шувуу гарсан тухай, "Монголын шуурга хойд Америкийг бохирдуулж байна" ("Өдрийн сонин", 2001, №92) мэдээнд Монголын говийн элс Хятадын аж үйлдвэрийн бохирдолтой холилдон Хойд Америк, Канадыг бохирдуулж байгаа тухай, Л.Цогтын хийсэн "Элсэн түймэр Улаанбаатарыг ч хуйхалж мэднэ" ("Зууны мэдээ", 2001, №71) ярилцлагад Цөл судлалын мэргэжилтэнтэй цөлжилтийн асуудлаар

ярилцсан зэргийг нэрлэж болно. Харин 25 хувийг эзэлсэн эерэг хандлагатай нийтлэлд "Өдрийн сонин"-ны "Эх орон сумаас эхэлнэ" буланд гардаг нутаг усны тухай дурсамж нийтлэлүүд голлох байр суурийг эзэлж байгаа бол төвийг сахисан нийтлэлүүдэд "Өдрийн сонин"-ы "Сав шимийн ертөнц" буланд нийтлэгддэг сэтгүүлч Ч.Чулуунцэцэгийн амьтдын амьдралын онцлог, үржил, үр ашгийн тухай сонирхолтой хэлбэрээр бичсэн нийтлэлүүд орж байгаа юм.

Экологийн нийтлэлийн агуулга, хандлагыг он тус бүрээр нь харьцуулан үзвэл:

Хандлага	1980-аад он	1990-ээд он	2000-аад он
Сөрөг	57.2	45	63.5
Эерэг	28	35	25
Төвийг сахисан	14.8	20	11.5
Нийт	100%	100 %	100 %

Дээрх үзүүлэлтийг аваад үзвэл ямар ч цаг үед сөрөг хандлагатай нийтлэлүүд давамгайлж иржээ. Энэ нь экологийн сэдэв өөрөө байгалийн гамшигт үзэгдлүүд, байгалийн нөөц баялгийн хайр гамгүй хэрэглээ, байгальд хандах хүний зүй бус ажиллагааг шүүмжлэх гэх мэт сэдэв, чиг хандлага голлодогтой холбоотой. Гэхдээ экологийн нийтлэлийн үр нөлөөг нэмэгдүүлж, уншигчдын сэтгэл зүй, ухамсарт нөлөөлөхын тулд эерэг,

сөрөг хандлагатай мэдээллүүдийг тэнцвэртэй нийтэлж байх нь зөв юм. Аль нэг нь давамгайлбал бас л сөрөг талтай.

Харин төвийг сахисан хандлагатай нийтлэлүүд нь идэвхгүй, тоо баримт тоочсон, уншигчдад байгаль орчны мэдлэг, мэдээлэл өгөхдөө тааруухан байдаг тул ийм хандлага бүхий нийтлэлүүд давамгайлах нь экологийн нийтлэлийн үр нөлөөг ихээхэн бууруулж байдаг юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Берлова О. 1998. Некоторые аспекты экологических паблик рилейшнз в России. Tasis.
2. Коханова Л. А. 1997. Журналистика. Экология. Образование. М.
3. Коханова Л. А. 2004. Экологический PR: составные профессии. М.
4. Реймерс Н. Ф. 1994. Экология. Теория, законы, правила, принципы и гипотезы. М.
5. Риклефс Р. 1989. Основы общей экологии. М.
6. Фридман Ш. М., Фридман К. А. 1998. Пособие по экологической журналистике. Tasis.
7. Чойсамба Ч. 2001. Экологийн сэтгүүл зүй. УБ.
8. Burkett W. 1986. News Reporting: Science, Medicine and High Technology. The Iowa State University Press: Ames, Iowa.

9. Lovelock J. Gaia. 1991. The Practical Science of Planetary Medicine. Gaia Books Limited, L.

10. Froster J. 1963. Science Writers Guide. Columbia University Press: N. Y.

Резюме

Автор в данной статье подробно рассматривает видоизменения и пертурбации, которые имели место в публикациях периодической прессы на экологическую тематику за 1980-2000-е гг. В частности, автор уделяет основное внимание жанрам, тематике, тенденции экологических публикаций. Важнейшим компонентами экологических публикаций является, по-мнению автора, постановка вопроса и подход к теме.